

## “ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

5 сарын 5, 2020

**П.Бадамрагчаа:** Хэлэлцүүлэг маань нэг цаг үргэлжилнэ. Маш өргөн хүрээний бодлогын асуудал яригдаж байгаа учраас аль болох асуудлынхаа гол руу орох хүмүүсийн сонирхож магадгүй гэсэн гол асуудлууд дээр төвлөрч ярихыг зорьж байна. Хэлэлцүүлэг эхлэхээс өмнө Ямар шатанд явж байгаа вэ гэдгийг нь Сайнзориг даргыг ажлын хэсэгт ажиллаж байгаагийн хувьд хууль боловсруулах үйл явц маань ямар шатандаа явж байна, процессын талаас нь бид нарт товчхон мэдээлээч гэж хүсэж байна.

**П.Сайнзориг:** ҮХ-ийн өөрчлөлт 2019.11.14-ний өдөр батлагдсан байгаа, энэ нэмэлт өөрчлөлтийн гол амин сүнснүүдийн нэг шүүх эрх мэдлийн асуудлын бие даасан хараат бусаар ажиллах энэ нөхцөл бололцоог хангах чиглэлээр өөрчлөлт оруулсан. Энэ хүрээнд Шүүхийн тухай хуулийг боловсруулах ажлыг ЗГ-ын түвшинд ХЗДХЯ хариуцан боловсруулж эхэлсэн. Мөн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хууль тогтоомжийг 20 он хүртэл боловсронгуй болгох, үндсэн чиглэл дээр, энэ бүх асуудлуудаа нэгтгэж ХЗДХЯ дээр ажлын хэсэг гарсан. Ажлын хэсэг УДШ, ШЕЗ, өмгөөлөгчдийн холбоо, ХЗҮХ, судлаачид болоод ХЗДХЯ-ны төлөөллүүд орсон ажлын хэсэг гарч хуулийн төсөл боловсруулж, ковидын цаг үед таарсан үед онлайн болон бүх шүүхүүд дээр биечлэн хүргүүлж, 41 шүүх буюу тухайн аймагт байгаа бүх шатны шүүхүүдээс саналуудыг нэгтгэж УИХ-д 4 сарын 10-ны өдөр өргөн баригдсан. Мөн Байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь дэмжээд УИХ-ын ажлын хэсэг гарч ажилласан. Ажлын хэсгийн даргаар УИХ-ын гишүүн Нямбаатар болон ажлын хэсэгт нэр бүхий нэлээн олон гишүүд ажиллаж байна. Хуулийн төслийн явц маань хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлдэх ажлын хэсэг ажиллаж байна.

**П.Бадамрагчаа:** Анхны хэлэлцүүлэг маань хэдийд төлөвлөгдөж байна?

**П.Сайнзориг:** Миний зүгээс хараахан хэлэх боломжгүй буюу энэ бол УИХ-ын тухай хууль, УИХ-ын дэгийн тухай хуулиар шийдэгдээд явах байх. Олон нийт мэдэж байгаа, ЗГ-ын өргөн барьсан төсөлтэй холбоотой зэрэгцүүлээд МУ-ын Ерөнхийлөгчөөс хуулийн төсөл өргөн барьсан. Ерөнхийлөгч буюу МХХ-ны зарим гишүүд хуулийн төсөл боловсруулж ерөнхийлөгчөөр дамжуулан өргөн барьсан гэж сонссон. Энэ төслийг ХЗБХ дэмжээгүй, одоо чуулганаар орох эсэх нь хүлээгдээд байж байна.

**П.Бадамрагчаа:** Таны дурдсанчлан хуулийн төслийг өргөн барих энэ асуудлыг авч үзэж байгаагийн нэг шалтгаан нь онцгой нөхцөл байдал буюу Шүүхийн тухай хуулийн төсөлтэй зэрэгцээд дахиад алтернатив хувилбараар ажлын хэсэг гараад шинэ хуулийн төсөл боловсруулж гаргасан байгаа. Аль аль ажлын хэсэгт орж ажилласан хуульч судлаачдын төлөөлөл энд байгаа учраас өнөөдөр бид нар зарим нэг асуудлууд дээр зарчмын хувьд нийлж байгаа болон зөрөлдөж байгаа ямар асуудлууд байх вэ гэдгийг гаргаж ирэхийг зорьсон. Эхний асуултаа энэ ажлын хэсэгт ажиллаж байсан хүмүүс дотор Сайнзориг дарга болон, Мөнх-

Эрдэнэ багшаас асуумаар байна. Хуулийн төслийн хувьд түрүүн хэлсэн ҮХ-ийн нэмэлт өөрчлөлт болон шүүхийн чиглэлээр орсон чухал 3 заалт байгаа. Нэг нь бол энэ ШЕЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнийг өргөтгөх тухай асуудал байгаа. Энэ үзэл баримтлал хэдийгээр нэг заалт мэт боловч ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийн өөрийнх нь үзэл баримтлал нь энэ төслүүд дээр туссан уу, та бүхний өөрсдийн төслийн хувьд. Энэ үзэл баримтлалыг юу гэж ойлгож байгаа вэ, одоо ажилласан төсөл маань яг энийг илэрхийлж үзэл баримтлалыг хадгалж хамгаалах хэмжээнд байгаа юу?

**П.Сайнзориг:** Мэдээж аливаа хууль тогтоомжийн асуудал олон нийтэд ил тод, эргээд эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдүүдийн санал бодлыг сонсож тусгаж явах ёстой. ЗГ-аас өргөн барьсан хууль бол энэ зарчмаар явсан. Өөрөөр хэлбэл суурь асуудал буюу ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийн үзэл санааг зайлшгүй тусгаж авч үлдсэн. Өөрөөр хэлбэл 49.5-д зааснаар ШЕЗ-ийн гишүүдийн 5-ыг шүүгчид дотроосоо сонгож бусад 5 гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно гэсэн. Яг энэ хүрээндээ ЗГ 10 гишүүнтэй байх ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг оруулж, орон тооны болон орон тооны бус гишүүнтэй байхаар оруулж өргөн барьсан байгаа. Шүүгчид 5-ыг сонгож өөрсдөө томилохоор ҮХ дээр заасан байгаа. Энэ үзэл санааг ЗГ-ын өргөн барьсан төсөл дээр суулгаж өгсөн. Өөрөөр хэлбэл МУ-ын шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсны байгууллага хэрэгжүүлэх Шүүгчдийн зөвлөл гэдэг институтийг байгуулъя. Энэ зөвлөлөөс УДШ, анхан болон давж заалдах шатны шүүгчдийн олонх оролцсоноор Шүүгчдийн зөвлөл нь 5 шүүгчдээ сонгоод томилох гэсэн үзэл санааг энэ хуулийн төсөлд тусгасан. Ерөнхийлөгчийнх өргөн барьсан төсөл дээр энэ 10 гишүүнийг УИХ томилохоор оруулж, хуулийг арай өөрөөр тайлбарлаад байх шиг байна. Бусад 5 асуудлыг бид хэн томилохыг Үндсэн хуулийн текст дээр тодорхой заагаагүй учир, бид ЗГ-ын түвшинд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг өргөн барьсан 62 гишүүнийн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг авч үзсэн, эргээд хэлэлцүүлгийн шатанд яригдаж байсан хурлын протоколуудыг авч үзсэн. 62 гишүүнээс 5 гишүүнийг дотроосоо, үлдсэн 5-ыг ХЗБХ-оос томилно гэж байсан, энэ үзэл санааг нь харгалзаж үзэх ёстой. Нөгөөтээгүүр өнгөрсөн цаг хугацаанд энэ шүүх эрх мэдлийн шүүгчийг шилж байсан алдаанууд байдаг, өөрөөр хэлэх юм бол шат шатны шүүгчдээс 1 төлөөлөл орно, дээрээс нь МХХ 1, ХЗДХЯ 1 төлөөлөл байсан. Яг эцсийн практик дээр ямар байсан гэвэл шат шатны шүүгчдээс нэг төлөөлөл орохоос гадна МХХ-ны Шүүгчдийн хорооноос нэр дэвшүүлчихдэг ШЕЗ-ийн шийдэж болох шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг шүүгч нар давамгайл байдлаар бүрдүүлээд байх тал байсан. Энэ алдагдсан балансыг ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтөөр засна гэдэг концепц явсан. Энэ хүрээнд энэ төслийг боловсруулсан гэдгийг юуны өмнө хэлмээр байна. Зэрэгцүүлж өргөн барьсан төсөл дээр энэ асуудлыг харгалзаж үзэхгүйгээр шүүгч нар 5-ыг сонгох асуудлыг Хуульчдын холбоо дамжуулж зохион байгуулж шийдэж өгнө гэхийн зэрэгцээгээр МХХ нэмж 3-ыг нэр дэвшүүлнэ гэхээр шүүгчид давамгайлсан 8 шүүгч ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд орохоор, шүүгчийн хараат бус байдал алдагдах, тодорхой эрх ашигт үйлчлэх байдал үүсчих вий гэдэг дээр болгоомжлол байна.

**П.Бадамрагчаа:** Мөнх-Эрдэнэ багшийн хувьд ҮХ-ийн үзэл баримтлал энэ хуулийн төсөлд ялангуяа ШЕЗ-ийн бүрэлдэхүүнтэй холбоотой хэсэгт хэр бэхжиж орж чадсан бэ?

**Т.Мөнх-Эрдэнэ:** Энэ өдрийн мэнд хүргэе. МУ-ын ерөнхийлөгчөөс өргөн барьсан шүүхийн тухай хуулийн багц төслийг боловсруулахдаа үзэл баримтлалыг анхаарсан. Ажлын хэсэгт эрдэмтэй судлаачид, олон хуульч судлаачид оролцсон гэдгийг хэлэх нь зүйтэй. Үзэл баримтлалын хувьд нэг зүйлийг онцолж хэлмээр байна. ШЕЗ гэдэг бол шүүгчийн бие даасан хараат бус шүүхийн бие даасан байдлыг хангах эрхэм чиг үүргийг хангадаг ийм байгууллага. Энэ чухал чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагыг бүрдүүлэх асуудал бол их анхаарал хандуулах ёстой. Байгуулах механизм журмыг зөв тогтоож өгч байж, байгууллага чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргээ бүрэн дүүрэн хангахаас гадна нэг чухал асуудал байна. Шударга шүүхээр шүүлгэх иргэдийн үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх механизмыг их анхаарсан. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, дахин сэргээх зайлшгүй бодитой шаардлага бий болсон. Нэмэгдүүлэх байдлыг хангах хамгийн оновчтой байх хувилбарыг судлаачид хэлэлцээд дэвшүүлсэн. ҮХ-д 2019.11.14 нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүний хүрээнд 5-ыг шүүгчдээс 5-ыг институтээс нээлттэй сонгон шалгаруулах байдлаар томилно гэсэн. **УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоол байгаа, энэ тогтоол ҮХ-ийн нэмэлт өөрчлөлттэй зайлшгүй холбоотой. Хуваарь баталсан байгаа, тэр хуваарийн тэр хуваарийн дагуу үзэхэд шүүхийн хуулийг, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг үзэл баримтлалын хувьд яаж хийх ёстой вэ гэдэг удирдамжийг хууль тогтоогчид өгсөн байгаа, тэр дотроос үзвэл ШЕЗ-ийг институтийн тэгш оролцоог хангах байдлаар хуульчлах ёстой гэсэн удирдамж явж байгаа. Яг тэрний дагуу Ерөнхийлөгчийн өргөн барьсан төслийг боловсруулсан.** Өөрөөр хэлбэл 5 шүүгч шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөс санал болгоно, энэ дээр бид нарын боловсруулсан төсөл ЗГ-ын өргөн барьсан төслөөс зарчмын зөрөлдөөнтэй байгаа, шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөс санал болгоно, үлдсэн 5 гишүүний нэгийг нь МУ-ын ерөнхийлөгч, нэгийг нь ХЗДХЯ, үлдсэн 3-ыг нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох МХХ-оос нэр дэвшүүлээд ингээд УИХ дээр нийтийн сонголт хийсний үндсэн дээр томилохоор зохицуулсан. Ингээд хуульчдын холбооны оролцоог манай хуулийн төсөл хангаж өгч байгаа нь ЗГ-ын боловсруулсан хуулийн төслөөс концепцын ялгаатай байгаа өөрөөр хэлбэл 2012 оноос хойш хуулийн салбарын шинэчлэл реформын хүрээнд МУ-ын ерөнхийлөгч өөрийн тодорхой эрх мэдлийг мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг төрөөс хараат бус институтэд шилжүүлж эхэлсэн. Тэр шилжүүлгийг хэвээр нь хадгалах бататгах ёстой гэдэг концепцыг барьж ШЕЗ-ийг бүрэлдэхүүнийг бүрдүүлэх журмыг бичиж өгсөн.

**П.Бадамрагчаа:** Сайнхишиг даргын хувьд ШЕЗ гэдэг байгууллага 2012 оноос хойш тодорхой туршлага хуримтлуулаад өөрсдийн гэсэн алдаа оноогоо эргэж харах боломжийг авч чадсан гэж бодож байна. Одоо ШЕЗ-ийн хувьд ямар байр суурийг авч явж байгаа вэ? Ж нь 10 гишүүнтэй болохыг дэмжиж байна уу, сонгох томилох асуудал дээр мөн арын албаны ажлыг хийдгийн хувьд ямар байр суурьтай байгаа вэ?

**Ж.Сайнхишиг:** Энэ өдрийн мэнд хүргэе. ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийн дагуу энэ ажил зохих журмын дагуу явагдаж байна, ШЕЗ-өөс оролцоод явж байна. ХЗДХЯ дээр ажлын хэсэг 2019 оны 12 дугаар сард байгуулагдаад үйл ажиллагаа явуулж байгаа. ШЕЗ-д 10 гишүүн байх асуудал нь ҮХ-д заасан учраас хууль ҮХ-д нийцэж гарна гэж үзэж байна. Тухайн үед ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтийг байхад ШЕЗ-ийн 5 гишүүн байгааг нэмэх шаардлагатай гэдэг саналыг бүх субъектүүдээс гаргасан, үүнийг бид бүхэн дэмжиж явдаг. Яагаад гэвэл МУ-ын нэрийн өмнөөс шүүн таслах ажиллагааг хуульд захирагдаж бие дааж гаргах шүүгчдийг сонгон шалгаруулах ажлыг өргөн мэдэх ажлыг зохион байгуулдаг байгууллага тал талын оролцоог хангасан байх ёстой. Тодорхой тооны гишүүдтэй байх ёстой гэдгийг үндэслэлийг гаргуулж ирсэн. Энийг нэг дүгээрт дэвшилттэй алхам гэж харж байна. 2-т ШЕЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг ямар субъект байх вэ гэдэг асуудал дээр ШЕЗ тодорхой байр сууриа илэрхийлсэн. 2020.01.30-ны өдөр ХЗДХЯ-наас шүүхийн тухай хуулийн төслийг олон нийтэд ил тавьж санал авсан. Манайхаас албан ёсоор санал авсан. ШЕЗ-өөс судалж үзээд ШЕЗ-ийн 10 гишүүний 5 нь шүүгчид дундаас сонгогдсон байх нь зүйтэй, үлдсэн 5-ын 2 нь ХЗБХ, ерөнхийлөгч, ХЗДХЯ, МХХ-ноос үдсэн гишүүд нь 1, 1 төлөөлөл байгаад тэд нарыг өөрсдөө бүрэн эрхийг нь баталгаажуулдаг, томилдог байх нь зүйтэй гэсэн санал ХЗДХЯ-д энэ оны 2.19-ний өдөр албан бичгээр хүргүүлсэн, ШЕЗ-ийн байр суурь ийм байна. Энэ асуудал МУ-ын ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтөд нийцэх ёстой. Товчхон бодлоо хуваалцахыг хүсэж байна. Шүүгчид дотроосоо 5 гишүүнээс сонгох гэсэн ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтөд заалт байгаа. Дотроосоо сонгоно гэхээр 1-т шүүгч хүн байх ёстой, өмнө бол үүнийг зааж өгөөгүй байсан. 2-т нь шүүгч нар бүрэн эрхийг нь шууд олгодог байх ёстой. Дараачийн нэг асуудал бол бусад 5 гишүүдийг нээлттэйгээр зарлаж томилох гэсэн, энэ 5 гишүүнийг сонгох субъект 2-3 байх тухай яригдаж байгаа. Энэ дээр ҮХ-ийн нэмэлт өөрчлөлтөд оруулсан нэг зүйл бол нээлттэйгээр гэсэн. Үүнийг бид ямар утгаар ойлгож байна гэхээр хуульд заасан болзол шаардлагыг хангасан, хууль зүйн өндөр мэргэшилтэй, танил тал татахгүйгээр нэр дэвшиж шударга өрсөлдөөнд орох бололцоог нь хангасан байх ёстой. Энэ бол өмнөх хуулиуд дээр дутагдалтай байсан, үүнийгээ ЗГ-ийн өргөн барьсан хуулийн төсөл дээр бүрэн хэмжээгээр оруулсан гэж үзэж байна. 60 хоногийн өмнө олон нийтэд нээлттэйгээр зарлана, энэ хүрээнд шаардлага хангасан хүмүүс нь ХЗБХ, ХЗДХ-ийн сайд, МУЕ-д өөрсдөө хандаад явахаар. Нээлттэй гэдэг дээр субъект гэхээсээ илүү процесс ажиллагаа нь чухал гэдгийг онцолж хэлж байна. Энэ субъектүүд нь өөрсдөө журмаа гаргаж өгөх ёстой. Журмаа урьдчилж батлаад ил тодоор процессыг шударга байхыг хангаж өгөх ёстой. Дараачийн нэг асуудал бол шүүгч гишүүдээ дотроосоо сонгоход шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдлаа, нээлттэй ил тод байдлыг хангахгүй байна гэдэг өмнөх шүүмжлэлүүд гардаг байсан. Бид бүхэн хууль хэрэгжүүлээд хэд хэдэн удаа ШЕЗ-ийн гишүүдийн ажлыг сонгох ажлыг зохион байгуулаад, техникийн туслалцаа үзүүлээд явсан. Шүүгчдийн зөвлөлөөс Ерөнхий зөвлөлийн 5 гишүүнийг сонгохдоо мөн нээлттэй ил тод байдлыг хангах, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах энэ журмаа урьдчилж гаргаж явах ёстой гэсэн нь энэ хуулийн төсөл дээр байгаа. Үүнийг ҮХ-ийн үзэл баримтлалтай нийцсэн болов уу гэж үзэж байгаа. Олон улсын туршлагыг товч дурдвал, ШЕЗ

гэдэг энэ байгууллага бол Европ тивд үүссэн. Европ тивийн эрх зүйн үзэгдэл гэж үздэг.

**П.Бадамрагчаа:** Сүүлийн 4-5 жил Оюуны инноваци ТББ-тай шүүх эрх мэдлийн хүрээний судалгаа шинжилгээний ажлыг хараат бус хөндлөнгийн байдлаас хийх талаар хамтран ажиллаж байна. Түүрэн дурдсан 2020 оны 1 сарын 30-ны байдлаар ХЗДХЯ-наас санал авахаар олон нийтэд нээлттэй тавигдсан төслийн хувилбар дээр хамтран ажиллаж Оюуны инновацийнхан хэд хэдэн судлаачдын оролцоотойгоор өөрсдөө өмнө хийсэн судалгаа дээр үндэслээд Хуулийн шүүмжийг гаргасан. Үүнийг ХЗДХЯ-д хүргүүлсэн, зарим зарим саналууд маань аль хэдийн тусгагдсан байгаа байх. Аль нэг ажлын хэсэгт ороогүй хараат бус хөндлөнгийн байр сууринаас харахад санал шүүмжээ танилцуулахгүй юу гэж хүсэж байна.

**П.Баттулга:** Манай байгууллагын хувьд хөндлөнгийн байр сууринаас хандаж байгаа, би өөрийн хувьд хувь судлаачийн зүгээс өөрийн итгэл үнэмшлийн хүрээнд хандаж байгаа. Эдгээр 2 төслийн хувьд ажлын хэсгийн гишүүдийн хувьд өөрсдийн төслийн давуу талыг хэлэх нь зүй ёсны асуудал. Гол асуудал бол ҮХ-ийн нэмэлт өөрчлөлт буюу 49-р зүйлийн 5 дахь хэсгийн хүрээнд энэ үзэл баримтлалын хувьд бол ялангуяа ШЕЗ-ийн бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлууд явах байх нь гарцаагүй. Энэ төслүүдийг харьцуулж харж байна, адил талтай зүйл ч байна, мөн өөр өөр зүйлүүд байгаа. Жишээ нь шүүгчид дотроосоо 5 гишүүнийг сонгох асуудал дээр ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсөл дээр шат шатны төлөөллийг хангаж шүүгчдийн зөвлөлөөс сонгох гэдэг зүйл байгаа ямартай ч 3 шатны шүүхээс нэг нэг төлөөлөл байна, бусад 2-ыг нь тухайн үедээ нээлттэй дэвшүүлээд шүүгч дотроосоо сонгох юм байна гэсэн агуулга харагдаж байна. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөл дээр анхан шатны шүүхээс 3, хяналт давж заалдах шатны шүүхээс тус тус 1 гэсэн өөр өөр зүйлүүд байна. Энийг тухайн үед УИХ-аар хэлэлцэх үед хэлэлцээд явах байх гэж бодож байна, бусад 5 гишүүний хувьд хаанаас нэр дэвшүүлэх вэ гэдэг асуудал байгаа. Энэ дээр ямар ч байсан 2 талын байр суурь бол ШЕЗ-ийн шүүгч бус 5 гишүүд хууль зүйн өндөр мэргэжилтэй хүмүүс байна гэдэг дээр санал нэгдэж байгаа дээр бидний зүгээс олзуурхууштай хандаж байна. Өөрөөр хэлбэл шүүгч бус 5 гишүүд маань өөр мэргэжлийн бус хүмүүс байхгүй юм гэдэг дээр талууд байр суурь нь нэгдэж байгаа нь харагдаж байна. Аль аль төсөл дээр ерөнхийлөгчөөс нэг гишүүн сонгоно гэдэг байна, гэхдээ бидний зүгээс нэг харж байгаа зүйл бол саяны ҮХНӨ-өөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой цогц заалтад өөрчлөлт орсон, 33.4 дэх хэсэгт Ерөнхийлөгчид олгох бүрэн эрхийг энэ зүйлд заасан хүрээнд хязгаарлаж олгоно гэсэн зохицуулалт байгаа. Энэ дээр бусад органик хуульд Ерөнхийлөгчид хэтэрхий их эрх мэдэл олгоод байна гэсэн шүүмжлэл ҮХНӨ-ийн төслийг хэлэлцэж байх үед гарсан. Энэ үзэл санаатай Ерөнхийлөгчөөс ШЕЗ-ийн нэг гишүүнийг сонгох асуудал нь хэр нийцэх бол гэдгийг цаашид хэлэлцэх байх гэж бодож байна. Нөгөөтээгүүр **ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсөл дээр ХЗБХ-оос 3 хүн байна, Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн төсөл дээр шүүгч бус 5 гишүүний хувьд МХХ-ноос 3 гишүүн байна гэх мэт өөр өөр зүйлүүд байна. Үүнийг хувь судлаачийн хувьд харж байгаагаар МХХ-оос одоогийн нэг хүнийг сонгоно гэж явж байгаа уламжлалаа хадгалаад явах нь зүйтэй болов уу** гэсэн байр суурьтай

байна. Бусад гишүүдийн хувьд ХЗБХ-д ч юмуу, нээлттэйгээр нэр дэвшүүлээд явахад бол болохгүй зүйл байхгүй гэж үзэж байна. Шүүгчид 5 гишүүнээ дотроосоо сонгох гэдэг дээр санал нэг байна. ҮХНӨ-ийн үзэл санаагаар бол шүүгчид дотроосоо сонгож байгаа гишүүд дээр нэмж томилж байгаа гишүүн дээр дахиж өөр субъектээс сонгоно гэдэг өмнө нь яригдаж байгаагүй. Энэ 5 шүүгч гишүүдийн хувьд бол шүүгч дотроосоо сонгоод шууд бүрэн эрх нь хэрэгжээд явах нь ҮХНӨ-ийн үзэл санаанд нийцэх юм гэсэн байр суурьтай байна.

**П.Бадамрагчаа:** ҮХ-ийн үзэл баримтлалынхаа хүрээнд ахиц дэвшилтэй, өмнө нь зохицуулалт байхгүй дутмаг байсан асуудлуудыг нэмж зохицуулж байгаа, хэн хаанаас журам гаргах вэ гэдгийг хүртэл зааж өгч байгаа ахиц дэвшлүүд гарч байна гэж ойлгож байна. Зарчмын хувьд санал зөрөөтэй байгаа хэд хэдэн асуудал байгаагийн гол зүйл нь бүрэлдэхүүний асуудал дээр байр суурийн зөрөө гарч байх шиг байна. 2 төслийг сонсоход аль аль нь олон хуульчдыг оролцуулах олон талын саналыг сонслоо гэж байна. ННФ-ын хувьд гаргасан санал шүүмжээ 2 ажлын хэсэгт тэнцүү гаргаад явж байсан. Эцсийн шийдвэрийг Их хурал дээр гаргах байх. Тодруулаад хэлэхэд МХХ-ны зүгээс нэр дэвшүүлэх асуудлыг хаа хаанаа санал гаргаад явж байгаа тохиолдолд энийг авах боломж нь хэр байдаг вэ олон нийтээс ирж байгаа саналууд ажлын хэсгийн явцад орох боломж байгаа юу? Үүнийг нэмэлтээр харж үзэх боломж байдаг уу гэдгийг асууя.

**П.Сайнзориг:** Хэлэлцүүлгийн шатанд байна, УИХ-ын ажлын хэсэг саналаа оруулах байх, ХЗБХ-ны гишүүд. Улсын их хурлын чуулганаар эцэслэгдэнэ. Үндсэн хуулийн үзэл баримтлалаа ойлгож ярихгүй бол, шүүгч нар өөрөө сонгох гэж байсан зүйлийг шүүгч нар санал болгож буй байдлаар хязгаарлаж байгаа зохисгүй байдал байна. Энийг эргээд МХХ-ноос боловсруулж байгаа ажлын хэсэг маань харгалзаж үзэх байх гэж найдаж байгаа. нэг талдаа найдаж байгаа, 2-т бол ажлын хэсэг дээр яригдаж байгаа, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг ҮХНӨ-ийн 33.4 дүгээр зүйлээр хязгаарласан гэдэг нь яригдаж байгаа. Ерөнхийлөгчийн санал болгож квотыг МХХ гэдэг ч юмуу мэргэжлийн холбоо санал болгох нь зөв юм гэдэг асуудал байхыг үгүйсгэхгүй. Ер нь зарчмын хувьд хэн нэг этгээд субъектив байдлаар санал болгох гэж байгаа зүйл байхгүй, бүх процедур нээлттэй ил тод нэр дэвшүүлэх ажиллагаа явагдана. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа явагдсаны дараа эргээд тодорхой хэлэлцүүлгүүдээр тодорхой шалгуураар олон нийтэд хэлэлцэгдэж байж томилогдох асуудал юм. Энэ 2 төслийг хуульчид маань анхаараасай гэж үзэж байна, өмнө нь ШЕЗ-ийн 5 гишүүний 4 нь үндсэндээ шүүгч гишүүд, шүүхийн хамааралтай гишүүд томилогдоод, энэ нь эргээд шүүгчийг сонгох асуудал нь хэт давамгай явагдаж байна гэсэн шүүмжлэл байсан. Энэ алдаа Ерөнхийлөгчийн зүгээс өргөн барьсан төсөл давтаж байгаад анхаарал хандуулаасай. Өөрөөр хэлбэр Шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөнөөс 5 шүүгчдийг сонгох үйл ажиллагааг МХХ зохион байгуулж өгнө гэсэн байна, мөн МХХ-ноос 3 гишүүн сонгохоор тэгш байдал алдагдах вий. Шүүгч бус гишүүдийг томилох асуудал дээр 33.4 дэх хэсгийг судлаачид анхааралтай авч үзээсэй, Ерөнхийлөгчийн олгогдсон бүрэн эрхүүдийг Үндсэн хуульд зааснаас бусад бүрэн эрхийг хязгаарлаж байгаа гэж ярьж байгаа боловч үндсэн хууль батлагдах текст өөрөөр гарчхаад байна, энэ зүйлд гээд заачихаар Ерөнхийлөгчийн эрх мэдэл ч юмуу ҮХЦ-тэй холбоотой эрх мэдлүүд нь 52-р зүйл,

65-р зүйл дээр байгаа. ҮХ-ийн энэ 2 заалтыг үндсэндээ жоохон зөрчилдөөнтэй байдлаар батлагдчих шиг боллоо. Тэгэхээр энэ нөхцөлүүдийг харгалзах ёстой. Ерөнхийлөгч заавал ШЕЗ-ийн хуульч бус гишүүнд нэр дэвшүүлэх шаардлагагүй гэж үзэх юм бол энийг ХЗБХ-ны ажлын хэсэг дээр үзээд мэргэжлийн холбоо нь цаашдаа нэр дэвшүүлэх бололцоотой гэж харж байна

**П.Бадамрагчаа:** МХХ-ны тухай асуудал тусдаа асуудал хэдий ч ШЕЗ-ийн өмнөх хуулийн хүрээнд нэлээн оролцоотой явж байсан гэдэг утгаараа энэ хүрээнд яригдах асуудал. Мөнх-Эрдэнэ багшаас асуухад ерөнхийлөгчийн эрх хэмжээний тухай асуудал, МХХ-ны зүгээс 5 гишүүнийг санал болгох үндэслэл нь хуулийг санаачлагчдын зүгээс ямар байгаа вэ? Яагаад ийм зохицуулалтыг оруулж ирүүлсэн талаараа тайлбарлавал?

**Т.Мөнх-Эрдэнэ:** Залруулга хийх хэрэгтэй байна. 8 хүн дэвшүүлэх гэж ойлгогдсон байна, тийм зүйл байхгүй, тэр шүүгч 5 гишүүнийг сонгох асуудалд МХХ-ны Шүүгчдийн хороо зүгээр зохион байгуулалтын асуудал дээр нь дэмжлэг үзүүлж оролцох юм, судлаачийн хувьд хариуцлагатай хэлье. Ерөнхийлөгчийн оролцоо бүрэн эрхийн асуудалд Сайнзориг даргатай зарим нэг зүйл дээр санал нэг байна. 33.4-т оруулсан нэмэлт өөрчлөлт бол Ерөнхийлөгч шүүгчийг томилох, шүүгчийг томилохтой холбогдуулж ШЕЗ-ийн гишүүнд санал болгох нэр дэвшүүлэх бүрэн эрхэд хөндөхгүй гэдэг дээр санал нэг байна, яагаад вэ гэхээр Ерөнхийлөгчийн институт нь өөрөө Шүүх эрх мэдлийн үндсэн хуулийн баталгаа нь байдаг, үндсэн хуулийн онол зарчмын дагуу. Ихэнх дэлхийн ихэнх улсуудад ерөнхийлөгч шүүгчийг томилдог. Яагаад гэвэл үндсэн хуулийн баталгаа нь Ерөнхийлөгч байдаг учраас. 2-т Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг бодож үзэх ёстой. Ерөнхийлөгч бусад төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудтай харьцуулахад улс төрөөс хараат бус байдаг, намаасаа түдгэлзсэн байдаг. Энэ утгаараа шүүх эрх мэдлийн үндсэн хуулийн баталгаа нь төрөөс хараат бус, улс төрөөс хараат бус, Ерөнхийлөгчид оногдох ёстой, дэлхий нийтийн түгээмэл жишиг нь тийм байгаа. ХЗБХ-ны 3, МХХ-ны холбоо 3 гэсэн зөрөөтэй байгаа. Яагаад ХЗБХ хүн нэр дэвшүүлж болохгүй гэж үзэж байгаа нь ХЗБХ нь улс төрийн байгууллага, 2-т ХЗБХ шүүх эрх мэдэлд томилгоо хийх ямар ч боломж байхгүй, томилгоо хийдэг эрхтэй субъект биш. Тийм учраас бидний хуулийн төсөлд төрөөс хараат бус мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох МХХ-д оролцоог нь нэмэгдүүлэх нь зөв шийдэл байна гэж харсан.

**П.Бадамрагчаа:** Энэ 2 төсөлд ямар ч тохиолдолд ШЕЗ-ийг үр нөлөөтэй хараат бус байдлаар ажиллуулахын тулд хэзээ ч хасаж болохгүй заалт, зайлшгүй авч үлдэх ёстой чухал заалт зохицуулалт нь юу вэ?

**Ж.Сайнхишиг:** Өнөөдрийн хэлэлцүүлгийн асуудал тодорхой ШЕЗ-ийн бүрэлдэхүүн, сонгох томилох журам гэж ойлгож байна. Шүүхийн захиргааны бие даасан ШЕЗ байгуулагдаад үйл ажиллагаа явуулаад бараг 30-аад жил болох гэж байна, 1992 онд ҮХ батлагдсанаас хойш. 2012 оны шүүхийн багц хуулийн нэг дэвшилтэт тал байгаа үзэл санааны, шүүхийн захиргааны бие даасан загварыг монгол улсад гаргаж ирсэн, ШЗБДГ гэдэг нь энгийнээр хэлбэл гол санаа нь ШЕЗ хууль тогтоох гүйцэтгэх эрх мэдлээс буюу төрийн бусад эрх мэдлээс шүүх эрх мэдлийг хамгаалах зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг гэж хэлж болно. Шүүгч хүн

өөрөө өөрийнхөө эрх ашгийг хамгаалаад хараат бус байдал гэдэг нь төвөгтэй гэдэг нь тод болсон, дэлхий нийтээр авч үзвэл. Энэ хүрээндээ энэ 2 төсөлд 2ланд нь шүүхийн захиргаа гэдэг тогтолцоог 2012 оны үзэл баримтлалыг нь авч үлдсэн байна, энийг авч үлдвэл давуу талтай. ШЕЗ-ийн загварын асуудал байдаг, дээд шүүхийн ерөнхий шүүгч нь хэрэгжүүлдэг, ХЗДХ-ийн сайд хэрэгжүүлдэг загварууд дэлхий нийтэд байдаг. Манай ҮХНӨ-өөр бие даасан загварыг нь салгаж үндсэн хуульчилсан. Энэ нь аль аль төсөл дээр явж байгаа, энэ үр дүн нь гарах болов уу. Өөрөөр хэлбэл Ерөнхий шүүгч хэрэгжүүлдэггүй, шүүхээс нь тусдаа бие даасан субъект, мөн ЗГ-ын системийн байгууллагаас бие даасан субъект. Хамгийн гол чухал зүйл бол 5 хүн нь шүүгч байх, нөгөө 5 нь шүүгч биш хуульч байх.

**П.Сайнзориг:** Үзэл санаа нь тодорхой гарсан. Шүүхийн захиргааны бие даасан институтийг монгол улс үндсэн хуулиараа баталгаажуулсан. Гишүүдийн бүрэлдэхүүнийг шүүгчид шат шатны төлөөллөөс шүүхийн зөвлөл гэдэг институтээс нууц санал хураалтаар 5 гишүүнээ сонгож гаргаж ирэх, бусад 5 нь тодорхой институтээс. Ямар ямар институт байх гэдгийг хууль тогтоогч эцэслэн шийдэх байх. Гол маргааны асуудал нь орон тооны байх уу, орон тооны бус байх уу гэдэг маргаан парламент дээр явж байгаа. нь сонгох, гээд тодорхой гарсан. Хувь хүний судлаачийн хувьд харж хэлэхэд тодорхой нэг загварыг бойжих хугацааг өгөөгүй, олгоогүй талууд байна, туршиж үзсэн загваруудаас явж явж бие даасан байх энэ загвар нь монголд илүү шүүх эрх мэдлийг бэхжүүлэх, хадгалах эргээд шударга шүүхээр иргэд шүүлгэхэд энэ загвар нь таатай юм гэж сонгосон учир энэ загвараар цаашдаа явах байх. Гол асуудал бол шүүгч нар 5-ыг шууд сонгоно гэдэг нь концепцийн хувьд үлдээсэн гэж хүсэж байна. Бусад 5 нь сүүлийн 5 жил улс төрийн алба хашиж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, нээлттэйгээр тодорхой хэмжээнд нэр дэвшээд гараад ирэхэд томилох асуудал нь дараагийн асуудал. Дараагийн асуудлыг хууль дээр тодорхой хэлсэн байгаа.

**Т.Мөнх-Эрдэнэ:** Санал нэг байна, ШЕЗ гэсэн бие даасан загварыг хадгалж авч үлдэх ёстой. 2-т шүүгчдийг хуульчдын дундаас шилж олох арга ажиллагаа хэлбэрийг хөгжүүлэх чамбайруулах шаардлагатай. 3-рт Ерөнхийлөгчийг өргөн барьсан төсөлд бас нэг чухал заалт байгаа, шүүх шүүгчийн албаны, болон ажил хэргийн нэр хүндийг хамгаалахтай холбоотой зохицуулалт оруулж өгсөн. Тэрийг яаж хамгаалах вэ гэхээр ШЕЗ-ийн ажлын албаны бүтцэд тусгайлан нэгж байгуулах. Сүүлийн үеийн харамсалтай кейсүүд байна, шүүхийн нэр хүнд рүү баримт нотолгоогүйгээр халддаг, шүүгчийн нэр хүндийг зохион байгуулалттайгаар унагаадаг. Үүнийг цааш нь байлгахгүйгээр шүүхийн нэр хүнд шүүгчийн нэр хүндийг хамгаалахын тулд ШЕЗ-д, бие даасан нэгж ажиллах ёстой гэдгийг оруулсан.

**П.Баттулга:** Шүүгч бус 5 гишүүний хувьд бол хууль зүйн өндөр мэдлэгтэй, 10-аас доошгүй жил ажилласан гэдэг нь хадгалагдаасай. Шүүгч бус 5 гишүүний хувьд анхаарах зүйл жишээ нь шүүгчээр ажиллаж байгаад ямар нэг шалтгаанаар албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, өөрийн хүсэлтээр, эрүүл мэндийн шалтгаанаар гм шалтгаанаар чөлөөлөгдсөн хүн тэр 5 хүнд орж ирвэл тэнцвэртэй байдал нь яах вэ, нөгөөтээгүүр ШТГ-ын дарга хийж байсан хүн шүүгч бус 5 хүнд орж болох уу энэ мэт хязгаарлалтуудыг харгалзаж тэнцвэртэй байдлыг хангах талыг



**анхаараасай гэж хүсэж байна.** Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөл дээр авах нэг зүйл бол төслийн 56.1 –д Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага байгаа. Одоогийн байгаа зохицуулалт л даа, энэ нарийвчилсан шаардлагуудыг уламжлаад авч үлдэх ёстой. Ингэвэл олон нийт нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх олон нийтийн зүгээс санал шүүмж гарахад ач холбогдолтой юм болов уу. Сүүлийн 5 жил улс төрийн албанд ажиллаж байгаагүй гэх мэт шаардлагууд нь нэлээн чухал шаардлага. 2 хуулийн төслийн аль алинд байгаа ШЕЗ-ийн гишүүний сахилга хариуцлагын асуудал, ёс зүйн дүрмээ зөрчсөн, ноцтой алдаа гаргасан бол хүлээлгэх хариуцлага, ямар сахилгын шийтгэл ноогдуулах вэ гэдэг нь аль алинд нь тусгагдсан байна. ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсөл дээр илүү нарийвчилж тусгасан байна, энэ зохицуулалтыг хэвээр нь цаашид улам боловсронгуй болгоод авч явах нь зөв гэсэн байр суурьтай байна.

**П.Бадамрагчаа:** Одоо байгаа 2 төслийн хүрээнд энэ төсөлд ерөөсөө орж болохгүй заалт нь юу вэ, ШЕЗ-ийг цаашаа хөгжүүлэхэд саад тотгор болно гэж үзэх?

**Т.Мөнх-Эрдэнэ:** Байж болохгүй заалт ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсөлд Шүүгчийн зөвлөл гэсэн шинэ бүтэц бий болгосон байгаа, энийг байж болохгүй гэж үзэж байгаа. Яагаад гэвэл тэр шүүгчийн зөвлөл бүтцэд бүгд орох юм уу гэхээр үгүй байна, УДШ-ийн шүүгчид бүгд орно, харин анхан болон давж заалдах шатны шүүхийн олонх нь гэсэн байна, ингэж шүүгчийн өөрөө удирдах ёсны бүтцийг хувааж болохгүй. Монгол улсад шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа бүх шүүгчид эрх тэгш асуудлаа шийддэг байх ёстой.

**П.Баттулга:** Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төслийн 53.10 дээр байна, ШЕЗ-ийн 10 гишүүнийг УИХ томилох нь бол Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй. Бүх 10 гишүүнийг УИХ томилох нь ҮХНӨ-ийн 49.5 дээр нийцэхгүй юм гэдгийг хэлмээр байна.

**Ж.Сайнхишиг:** Тодорхой нэг заалт гэхээс илүү өмнө нь ярьсан зүйлээс онцлохыг хүсэж байна. Бусад 5 гишүүнийг сонгоход аль нэг субъектэд илүү эрх мэдлийг өгч болохгүй, тэнцвэртэй байдал алдагдана. Монголын нөхцөл байдлыг харах ёстой. Ерөнхийлөгчөөс байж болно, ХЗДХЯ-тай шүүхийн тогтолцоо уялдаа холбоотой байдаг, зайлшгүй нэг хүн байх ёстой, парламентаас байж болно, мэргэжлийн холбооноос байж болно. Харьцуулсан судалгаагаар бол дэлхийн ихэнх улсуудад төлөөллийн загвар нь түгээмэл байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

**П.Сайнзориг:** Баттулга судлаачтай санал нэг байна, шүүгч 5 гишүүнийг сонгох асуудлыг шүүгч нарт үлдээх ёстой. Энэтэй холбоотой Ерөнхийлөгчийн зүгээс өргөн барьсан төслийн заалт бол дэмжигдэх боломжгүй байх. Хуульчид маань нэг зүйл дээр санал нэг байгаа, ШЕЗ хараат бус бие даасан байх ёстой гэдэг дээр бүгд санал нэг байгаа учраас цаашдаа төслийг хэлэлцүүлгийн шатанд сайжруулах боломжтой гэж харж байна.